

2007 ОНЫ I УЛИРАЛД ОЛОН УЛСАД БОЛСОН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

- 01.03 *Европын холбоо эгнээгээ тэллээ.* Шинэ он гараад Европын холбоо өрх гэртээ Балканы хоёр орон Болгар, Румынийг хүлээн авч, гишүүдийнхээ тоог 27 болголоо.
- 01.04 *Буш 2007 оны тэргүүлэх зорилтоо нэрлэв.* Цагаан ордны эзэн хоёр оны заагт АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдтэйгээ Техаст уулзахдаа Иракийн талаар явуулах шинэ бодлогоо тодорхойлсон байна.
- 01.10 *АНУ-ын атомын шумбагч Японы ачааны хөлөгтэй мөргөлдөв.* АНУ-ын атомын шумбагч хөлөг Японы ачаа тээврийн усан онгоцтой Арабын тэнгисийн Ормузын хоолойд мөргөлдсөн тухай Франс пресс агентлаг мэдээлэв. Азаар хүний амь эрсдээгүй, ноцтой сүйтгэл дагуулаагүй байна.
- 01.11 *Орос, Беларусь хоёрын ам зөрөө.* “ОХУ-тай хийсэн хоёр талын тохиролцоогоо харгалзан, манай нутгаар дайран өнгөрөх дамжуулах хоолойгоор бусад орнуудад өгч буй газрын тосонд гаалийн татвар ногдуулах талаар гаргасан шийдвэрээ Засгийн газар цуцалсныг хүлээн зөвшөөрч байна” хэмээн Беларусийн Ерөнхий сайд Сергей Сидроский зарлав.
- 01.25 *Макаогийн казино орлогоороо Лас Вегасыг гүйцэв.* Хятадын тоглоомын үйлдвэрийн төв Макао өнгөрсөн онд 6.9 тэрбум долларын орлого олж, 6.6 тэрбум долларын орлоготой ажилласан АНУ-ын Лас Вегасын казиног анх удаа гүйцэж түрүүлсэн тухай Блумберг мэдээлэв.
- 01.29 *Иракийн дайныг зогсоохыг шаардав.* Иракийн дайныг хязгаарлах цаг нь болсон хэмээн үзэж байгаа олон мянган америкчууд Вашингтон хотод өргөн далайцтай эсэргүүцлийн ажиллагаанд оролцов.
- 01.30 *Япон, Хятадын харилцаа сайжрах нь.* Филлипинд болсон Ази, Номхон далайн орнуудын чуулган дээр Японы ерөнхий сайд Шинзо Абэ, Хятадын ерөнхий удирдагч Вэн Жябао болон Өмнөд Солонгосын ерөнхийлөгч Но Му Хёнтой уулзалт хийсний дараа

- сүүлийн хэдэн жил ихэд муудсан хөрш гурван орны харилцаа сайжрах төлөвтэй болоод байна.
- 01.31 *Хятад “Эрийн цээнд хүрснээ” харуулав.* Хятадын туршилтын үр дүнгээр бол тэд манай радиолокацийн станцыг ч устгаж чадах юм байна. Гэтэл Сергей Ивановын хэлснээс үзвэл: “Хятадын пуужингуудыг манай станцууд ер “үзсэнгүй”. Уг нь Красноярскд байсан радиолокацийн төхөөрөмж л Хятадын бүс нутгийг бүхэлд нь ажиглачихаж чаддаг байсан юм” гэв.
- 02.01 *Японы арга хэмжээ 74 сая долларын хохирол учруулав.* Японы эдийн засгийн хориг арга хэмжээ Хойд Солонгост 74 сая долларын хохирол учрууллаа хэмээн эдийн засагчид тооцоолов. 2006 оны 10-р сард Хойд Солонгосын барааны импортод хориг тавьсны дараа Пхеньян гадаад худалдааны орлогын 25 хувиа алджээ.
- 02.05 *Моссад Ираны физикчийг хөнөөжээ.* Израилийн тагнуулын нууц алба Моссад Ираны алдарт цөмийн физикч Ардершир Хассан пурыг хөнөөлөө хэмээн Иранд үйл ажиллагаа явуулдаг Фарда радио станц мэдээлэв.
- 02.07 *Энэтхэгт далавчит пуужин туршжээ.* Энэтхэгийн эрх баригчид зэвсэглэлдээ онцгой анхаарч байгаа гэдэг нь үнэн гэдгийг баталж тэд Бромас хэмээх далавчит пуужин туршжээ.
- 02.10 *Бээжинд нулимахыг хориглов.* 2008 оны олимп эхлэхийн өмнө Хятадын нийслэл соёлгүй байдалд дайн зарлалаа. Юуны өмнө орон нутгийн оршин суугчдад нулимахыг хориглов. Гудамжинд шүлсээ хаясан хүмүүсийг “торгоно” гэсэн том гарчигтай сануулга сонинд гаргасан байна.
- Тайваний сүлд дуугаар Хятадыг бухимдуулжээ.* Карибийн тэнгис дэх Гренада хэмээх бяцхан арал улсад БНХАУ-ын тусламжтайгаар баригдсан цэнгэлдэх хүрээлэнг нээх ажиллагаан дээр Хятадын төрийн дууллын оронд Тайванийнхыг тавьж, дипломат ёс алдсан тухай АР мэдээлэв.
- 02.14 *Тайваний компаниуд Хятад “овгоо” солилоо.* Тайваний Ерөнхийлөгч Чэн Шуйбянь төрийн өмчит хоёр үйлдвэрийнхээ нэр дэх “Хятад” гэсэн үгийг өөрчилж “Тайвань” болголоо.

- 02.15 *Хятадын компаниуд Орос 12 тэрбум долларын хөрөнгө оруулна.* Орос-Хятадын харилцаа түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрээд байна. Хоёр орны төрийн тэргүүн нар 2006 оны зун Санкт-Петербургт уулзаж Үндэсний жилийг харилцан тэмдэглэх болсонд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн. 2020 он гэхэд Хятадын компаниуд Оросын эдийн засагт 12 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийхээр амлаад буй.
- 02.16 *Хятадын коммунист намын 21 мянган гишүүн намын батлахаа хураалгав.* Шанхай хотноо 1921 онд байгуулагдсан Хятадын коммунист нам гишүүнчлэл, боловсон хүчний асуудлаар алсын хараатай бодлого явуулж 70 сая гишүүн бүхий намынхаа эгнээг тэлээд зогсохгүй цэвэршүүлэх арга хэмжээ авсан хэвээр байна. Хятадын коммунист нам ноднин жил голдуу хээл хахуулийн хэрэгт орооцолдсон 21120 гишүүнийг намаасаа хөөлөө гэж “Синхуа” мэдээлэв.
- 02.23 *Продийн Засгийн газар огцорлоо.* Италийн Засгийн газрын тэргүүн Романо Продийн огцрох тухай хүсэлтийг Ерөнхийлөгч Жоржо ёсоор болголоо.
- 02.26 *Хамгийн үнэтэй зоос Канадад гарна.* Австрийн “Би Фил” алтан зоос өнөөг хүртэл дэлхийн хамгийн том зоосон мөнгөнд тооцогдож байгаа. Венийн филармонийн дурсгалд зориулан гаргасан уг алтан зоос нь 100 мянган евротой тэнцэх үнэ бүхий 3.1 кг жинтэй. Мөдхөн энэхүү дээд амжилтыг Канадууд эвдэх нь. Дэлхийн хамгийн үнэтэй бөгөөд хамгийн том зоосон мөнгийг ирэх сард Канадын хатан хааны зоосны ордноос гаргахаар ажиллаж байна. 99.999-ийн сорьцтой алтаар хийх уг зоос нь нэг сая доллартай тэнцэхүйц үнэтэй, жингээрээ 100 кг байх аж.
- 03.08 *Хамгийн үнэтэй хотуудын жагсаалт.* “Economist” сэтгүүл нь уламжлалт ёсоор амьдралын өртөг өндөр хотуудын жагсаалт гаргалаа. Дэлхийн 132 хотод амьдралын өртөг ямар байгааг мэргэжилтнүүд судалсан байна. Лондонд амьдралын өртөг Токиогоос 25 хувиар их. Их Британийн нийслэлд Норвегийн нийслэл Осло, Парис, Копенгагентай харьцуулах юм бол хямд байна. Манчестер болон Нью-Йорк хотуудад өртөг ижилхэн болохыг мэргэжилтнүүд тогтоосон байна.

- 03.15 *Хятадад 80 мянган хүн ундны усгүй болсон байна.* Хятадын зүүн хэсгийн Зянсу мужид ундны эх үүсвэрүүд химийн бодисоор бохирдсноос орон нутгийн 80 мянган оршин суугч уух усгүй болсон байна.
- 03.16 *Олимпын зочлод дэлхийн хамгийн урт автобусаар үйлчилнэ.* Бээжингийн олимпод морилох зочдын хөлөглөх 300 хүний багтаамжтай, дэлхийн хамгийн урт автобусыг Хятадад бүтээлээ. Олимпын зочлод зориулан тусгайлан үйлдвэрлэсэн автобусыг “Азийн автобусны ертөнц-2007” үзэсгэлэнд тавьж сонирхуулжээ. Эл автобус нь 25 метр урттай, дөрвөн тэнхлэгтэй, Жэзян мужийн автомашины “Цыннъян” корпорацид угсарсан энэ супер автобус нь байгаль орчныг бохирдуулахгүй байх орчин үеийн шаардлагад нийцсэн байна. Анхны зорчигчид нь Бээжин хот болон Жэзян мужийн засаг захиргааны төв Ханжоугийн оршин суугчид байсан байна.
- 03.17 *Ангарагийн хөлдүү усны хэмжээг тодорхойллоо.* Ангараг гаригийн өмнөд туйл дахь мөсөн голын зузаан 3.7 км болохыг эрдэмтэд тогтоов. Уг мөсийг буталж хайлуулбал гаригийн гадаргууг 11 метрийн гүнтэй ус бүрхэх гэнэ. Бүтцээр нь авч үзвэл мөсөн “Нуурын” дор хаяж 90 хувийг хөлдүү ус бүрхэх аж. Мөсний хэмжээг тогтооход Европын сансрын автомат станц “Марс-Экспресс”-т суурилуулсан радарыг ашиглажээ. *АНУ, Хойд Солонгосын мөнгийг чөлөөлжээ.* АНУ-ын Сангийн яам Макоагийн банкны Америкийн санхүүгийн системтэй харилцах боломжийг хаалаа. Ингэснээр тус банкинд хадгалагдаж буй өөрийн хөрөнгийг ашиглах үүд хаалга Хойд Солонгост нээгдэж байна гэж “Вашингтон таймс” мэдээлсэн байна.
- 03.20 *Дэлхийн хамгийн том агаарын хөлөг аялалд гарсан байна.* Зорчигч тээврийн “Аэробус А-380” нисэх онгоц энэ өдөр анхныхаа аялалд гарсан байна. Хоёр давхар танхимтай, 24 метр өндөр, энэ онгоц нэг удаагийн нислэгээр 15,000 км зам туулах чадвартай аж.
- 03.23 *Хятадын хүн ам нэг тэрбум 314 саяд хурлээ.* Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их хурлын X хуралдааны тав дахь удаагийн чуулган 3 сарын 5-6-ны хооронд Бээжин хотноо болжээ. Монгол Улсад суугаа

Хятадын элчин сайдын яамнаас энэ талаар хийсэн мэдээллээс үзвэл 12 өдөр үргэлжилсэн хуралдаанаар хоёр хууль, дөрвөн илтгэл, таван төслийн тухай тайланг хэлэлцэн баталжээ.

Хувийн компани сансарт пуужин хөөргөв. АНУ-ын SPACE X хувийн өмчийн компани өөрсдийн зохион бүтээсэн “Falcon-1” сансрын пуужинг тойрог замд гаргах анхны туршилтаа хийв.

- 03.27 *Ху Жинтао Москвад айлчлав.* БНХАУ-ын дарга Ху Жинтао өчигдөр өглөө Бээжингээс Москвад хүрэлцэн ирлээ. ОХУ-д хийсэн 3 өдрийн албан ёслолын айлчлалынхаа үеэр тус улсын Ерөнхийлөгч В.Путинтэй хэлэлцээ хийж, Ерөнхий сайд М.Фрадков болон албаны бусад хүмүүстэй уулзаж, Оросын талтай хоёр тэрбум ам.долларын өртөгтэй гэрээнд гарын үсэг зурав.
- 03.28 *Европчууд нэгдсэн номын сантай болов.* Европын нэгдсэн тоон номын сан байгуулах ажил гараагаа эхэллээ. Францын Ерөнхийлөгч асан Жак Ширак бүр 2005 онд соёлын ийм төсөл хэрэгжүүлэхийг санал болгож байсан юм. Нийтийн 23 номын сан оролцох төслийн хүрээнд хоёр сая боть ном, кино, гэрэл зураг болон гар бичмэлийг нэгдсэн бүртгэлд оруулах юм. Эдгээр нь үндсэндээ Европын соёлын сан хөмрөгийн “гишүүд” байх аж.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Өнөөдөр” сонин
2. “Өдрийн мэдээ” сонин
3. www.Dailynews.mn
4. www.olloo.mn
5. www.naver.com
6. www.daum.net
7. www.parl.gov.mn

Хэвлэлд бэлтгэсэн: Н.Бямбадорж (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан)